



2024 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан



100% ДИЖИТАЛ, 100 САЯ ХҮРТЭЛХ

Flexibusiness

Монголдоо төдийгүй ЗҮҮН ӨМНӨД АЗИДАА АНХДАГЧ
барьцаа хөрөнгө шаардахгүй 100% дижитал бизнесийн зээл

Агуулга

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2024 оны I улирлын
санхүү, үйл ажиллагааны тайлан

01

Бизнесийн үйл
ажиллагаа

02

Санхүүгийн
үзүүлэлтүүд

03

Онцлох
үйл явдлууд

04

Компанийн
засаглал

100% ДИЖИТАЛ, 100 САЯ ХҮРТЭЛХ
Flexibusiness

2024 ОНЫ I УЛИРЛЫН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Салбарын тойм

2023 оны 4-р улирлын байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан судалгаагаар 2023 онд нийт 529 ББСБ үйл ажиллагаа явуулжээ. Тэдний нийт зээлийн багц 3.7 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд салбарын хэмжээнд өмнөх онтой харьцуулахад 35% буюу 953.3 тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнээс 89.7%-ийг хэвийн зээл, 3.3%-ийг хугацаа хэтэрсэн зээл, 7%-ийг чанаргүй зээл эзэлж байна. Түүнчлэн, олгосон зээлийн 66.7%, төлөгдсөн зээлийн 68.1%-ийг хэрэглээний зориулалттай зээл

бүрдүүлж байна.

Мөн Монгол улсад Финтек зээлийн үйлчилгээ үзүүлэгч 55 ББСБ байгаагаас 6 нь зөвхөн технологид суурилсан, 49 нь технологи болон уламжлалт зээлийн үйл ажиллагааг хослуулдаг. Зөвхөн технологид суурилсан зээл олгодог ББСБ-уудын хувьд уламжлалт зээлийн үйлчилгээ үзүүлдэг ББСБ-уудтай харьцуулахад олгосон болон төлөгдсөн зээлийн эргэлт сайн байгааг Санхүүгийн Зохицуулах Хорооны судалгаанд дурджээ.

ЛэндМН-ийн үйл ажиллагаа

“ЛэндМН ББСБ” ХК нь технологид суурилсан зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын хувьд өдөрт дунджаар 9-10 мянга гаруй зээлийг олгодог. 2024 оны I улирлын байдлаар 211.3 мянган гэрээт харилцагчид 791 мянган зээлийг аппликейшнээр дамжуулан олгосон бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад харилцагчийн тоо 6.4%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Бид 2024 он буюу энэ жилээс эхлэн зөвхөн хэрэглээний зээл бус “Flexi business” бизнесийн зээлийг 100% дижиталаар харилцагч нартаа хүргэж эхэлсэн Монголдоо анхдагч байгууллага боллоо. Үүний үр дүнд 2024 оны эхний улиралд зээлийн багц 156.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 101.0%, 2023 оны 4-р улирлаас 24.5% тус тус өссөн.

Олгосон зээлийн дүн өмнөх оны мөн үеэс 35.1% өсөж 296 тэрбум төгрөг болсон бол нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээл 4.2% байна.


2024 оны I улирлын байдлаар нийт

орлого 17.9 тэрбум төгрөг, цэвэр ашиг 7.2 тэрбум төгрөгт хүрлээ.

“ЛэндМН ББСБ” ХК нь бизнесийн орлоготой харилцагчдадаа зориулан уян хатан нөхцөлтэй “Flexi business” зээлийн бүтээгдэхүүнийг ямар ч барьцаагүй, 2 минутад дижиталаар шийдвэрлэн ажиллаж байна. Харилцагч нь өөрийн бизнесийн хэрэгцээндээ нийцүүлэн боломжит зээлийн эрхийн хэмжээгээ хамгийн хялбараар аппликейшнээр тогтоолгож, тухайн зээлийн эрхийн хэмжээн дотроо хүссэн дүнгээрээ, олон давтамжтайгаар зээл авах болон эргүүлэн төлөх боломжтой. Энэхүү “Flexi business” бизнесийн зээлийн бүтээгдэхүүн нь харилцагчдын банк санхүүгийн байгууллагад зээлийн хүсэлт гаргах, судалгаа хийлгэхэд шаардагдах цаг хугацааг хэмнэхээс гадна бизнес эрхлэгчдийн дунд хамгийн хүндрэлтэй асуудал болох барьцаа хөрөнгийг шаардахгүй гэдгээрээ жижиг дунд бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөжүүлэх боломжийг олгож байна.



ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны I улирлын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн голлох үзүүлэлтүүд /сүүлийн 3 улирлаар/:



Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Нэгтгэсэн/

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Тэрбум төгрөг/	2023.III /Аудитлагдсан/	2023.IV /Аудитлагдсан/	2024.I /Аудитлагдаагүй/
Нийт орлого	12.5	14.6	17.9
Хүүгийн зардал	(2.7)	(2.7)	(3.9)
Цэвэр орлого	9.8	11.9	14.0
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	(1.0)	(0.7)	(0.9)
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(1.1)	(0.3)	(1.5)
Үйл ажиллагааны цэвэр орлого	7.7	10.9	11.6
Удирдлагын болон үйл ажиллагааны зардал	(1.6)	(2.0)	(2.1)
Татварын өмнөх ашиг	6.1	8.9	9.5
Татварын зардал	(1.4)	(2.1)	(2.3)
Цэвэр ашиг	4.7	6.8	7.2

Санхүү байдлын хураангуй тайлан /Нэгтгэсэн/

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2023.III /Аудитлагдсан/	2023.IV /Аудитлагдсан/	2024.I /Аудитлагдаагүй/
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4.8	7.9	9.6
Зээлийн багц (цэвэр)	94.7	123.5	154.1
Бусад хөрөнгө	3.3	0.5	0.6
Үндсэн хөрөнгө	0.7	1.3	1.3
Биет бус хөрөнгө	0.4	0.3	0.3
Нийт хөрөнгө	103.9	133.5	165.9
Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/			
Өр төлбөр	68.0	90.8	116.0
Эх үүсвэр	57.4	79.3	90.0
Хоёрдогч өглөг	2.8	2.8	2.8
Бусад өглөг	7.8	8.7	23.2
Эздийн өмчийн дүн	35.9	42.7	49.9
Хувьцаат капитал	8.5	8.5	8.5
Хуримтлагдсан ашиг	27.4	34.2	41.4
Нийт өр төлбөр болон эздийн өмч	103.9	133.5	165.9

КОМПАНИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



“ЛэндМН ББСБ” ХК нь өрхийн болон жижиг дунд бизнес эрхлэгч нарт тулгардаг гол асуудлууд болох барьцаа хөрөнгө, цаг хугацааг шийдсэн цоо шинэ бизнесийн зээлийг харилцагч нарынхаа хэрэгцээнд тулгуурлан, зах зээлд нэвтрүүлээ.


ЛэндМН нь харилцагчдадаа зээлийн үйлчилгээ үзүүлэхдээ хэзээ ч барьцаа хөрөнгөд тулгуурладаггүй, харин харилцагчдынхаа бизнесийн онцлог, тогтвортой орлогод тулгуурлан, 100% дижитал зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгодгоороо онцлогтой.

Энэхүү “Flexi business” бизнесийн

зээлийн бүтээгдэхүүнээ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан эмэгтэй бизнес эрхлэгчдэдээ эхний ээлжинд танилцууллаа.

Тус зээлийн бүтээгдэхүүн маань маш богино хугацаанд танилцуулагдаж, эхний 100 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд олгогдсон хэдий ч бидэнд хандан хүсэлт гаргасан мянга мянган харилцагч нартаа талархал илэрхийлье.

ЛэндМН-ийн зүгээс хүсэлтээ ирүүлсэн хүн бүрийг энэхүү үйлчилгээндээ бүрэн хамрагдах боломжийг олгохоор шат дараатай ажиллаж байна.



“ЛэндМН ББСБ” ХК нь 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа амжилттай зохион байгуулж, 6 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, хурлын үеэр шинэ “Flexi business” бүтээгдэхүүнээ танилцууллаа.



“ЛэндМН ББСБ” ХК нь 2023 оны цэвэр ашгийн 29.9%, компанийн нэгж хувьцаанд 8.0 (найм) төгрөг ногдуулж, 5.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олголоо.



Монголын ард түмний оюун санаагаар бүтсэн эх хэл, ардын зан заншил, мэдлэг ухаан, дуу хөгжим, тоглоом наадаан, ардын арга ухаан, уламжлалт технологи зэрэг соёлын өвийн олон төрлөө үр удамдаа өвлүүлэн үлдээхийг уриалан сануулж “Өв соёлоо хамтлаа асаая” компаниг ажлыг өрнүүллээ.



“ЛэндМН ББСБ” ХК нь Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд 5.0 тэрбум төгрөгийн “Лэнд Бонд”-ыг амжилттай татан төвлөрүүллээ.


КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Хувьцаа Эзэмшигчдийн Хурал

“ЛэндМН ББСБ” ХК нь 7 дахь жилдээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тасалдуулахгүй амжилттай зохион байгуулан ажиллалаа.

Компанийн зүгээс Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу Компанийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Бэст Вэстэрн Примьер Туушин зочид буудал (Best Western Premier Tuushin Hotel)”-ын 5 давхарт байрлах “Соёмбо” танхимд зохион байгуулсан ба саналын эрх бүхий хувьцааны 81.7% буюу 603,983,333 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор тус хурал хүчин төгөлдөр болсон ба дараах асуудлыг хэлэлцэн баталсан юм. Үүнд:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг батлах;
- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.



ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn

2024 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайланг бэлтгэсэн:
Маркетингийн албаны менежер Б.Батбилэг
Хянасан: Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр